

Япон хэл дээр уран илтгэлийн тэмцээний удирдамж

Ерөнхий зохион байгуулагч:
АМЖ-Япон дахь Монгол Иргэдийн
Нэгдсэн Холбоо

Хамтран зохион байгуулагч:
Монгол улсаас Япон улсад
суугаа Элчин Сайдын Яам

Тэмцээний зорилго

Япон улсад сурч, ажиллаж амьдарч буй иргэд, оюутан залуусынхаа мэдлэг чадвараа хөгжүүлж өөрийгөө нээн илрүүлэх, дуу хоолойгоо бусдын өмнө уран яруу илтгэх урлагт суралцах, мөн Япон улсад суралцахаар ирж буй оюутан залуусдаа үлгэр дуурайлал болох сурч мэдсэн мэдлэгээ бусаддаа мэдээлэл болгон хуваалцах, хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлэхэд тус тэмцээний зорилго оршино.

Хамрах хүрээ

Япон улсад сурч буй оюутан залуус, сурагч, ажиллаж амьдарч буй иргэд.

Шалгаруулах түвшин:

- 1-р түвшин 10-15 насны сурагчид
- 2-р түвшин Япон хэлний бэлтгэл эсвэл Коллежийн оюутан (Япон хэлийг 1~3 жил үзсэн)
- 3-р түвшин Их дээд сургуулийн оюутан эсвэл Япон улсад төрж, өссөн 16-с дээш насны хүүхэд залуус (Япон хэлийг 4-с дээш жил үзсэн)

Сэдэв

- 1-р түвшин “Миний хайртай Монгол орон”
- 2-р түвшин “Япон орноос суралцахуй”
- 3-р түвшин “Зөв хандлага миний бодлоор”

Шагнал

1-р түвшин

Тэргүүн байр : 20,000¥, Батламж, бэлэг дурсгалын зүйл
Дэд байр : 10,000¥, Батламж, бэлэг дурсгалын зүйл

2-р түвшин

Тэргүүн байр: 30,000¥, Батламж
Дэд байр: 20,000¥, Батламж

3-р түвшин

Тэргүүн байр: 40,000¥, Батламж
Дэд байр: 30,000¥, Батламж

Үзэгчдийн нэрэмжит шагнал: 1 хүн, 10,000¥, Батламж.

2-р шатанд шалгарсан оролцогчиддоо бяцхан гарын бэлэг гардуулна.

Бүртгэл

Тэмцээнд оролцохыг хүсэгчид Тус холбооны вэб хуудсанд үүсгэсэн оролцогчдын бүртгэлийн анкетыг **1-р сарын 25-ны** дотор бөглөж илгээсэн байна. (Овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар зэргийг сайтар хянаж зөв бичих) Линк: <https://www.amj.or.jp/apply-form>

Тэмцээн явагдах үе шат

Уран илтгэлийн тэмцээн нь 2 үе шаттай явагдана.

Нэгдүгээр шат:

Тэмцээнд оролцохоор бүртгүүлсэн нийт оролцогчид **2020 оны 1-р сарын 25** ныг хүртэл шалгаруулалтанд оруулах илтгэлээ Холбооны мэйл рүү илгээнэ.

Хоёрдугаар шат:

Нийт оролцогчдын сэдвийн дагуу бичиж илгээсэн илтгэлийг шүүгчдэд танилцуулан шүүлгэж, 2-р шатанд оролцох эрх авсан илтгэгчдийн нэрсийг **2020 оны 1-р сарын 31-нд** фэйсбүүк, вэбээр зарлах ба утсаар холбогдож мэдэгдэнэ.

Нийт оролцогчдын илтгэлээс түвшин тус бүрт **5** хүн шалгаруулах ба 2-р шатанд **15** хүн оролцоно.

2-р шатны шалгаруулалтыг **2020 оны 2-р сарын 8-ны** бямба гаригт Монгол улсаас Япон улсад суугаа ЭСЯ-ны байранд **12:00 цагаас** эхэлнэ.

- ✧ Бүртгэлийн хураамж байхгүй.
- ✧ Тухайн өдөр үзэгч, дэмжигчид үнэ төлбөргүй.
- ✧ Элчин сайдын яамны хаяг: とうきょうとしがやかくみやまちょう 東京都渋谷区神山町21-4.

Тэмцээний оролцогч, илтгэлд тавигдах шаардлага:

Нэгдүгээр шатанд:

- Илтгэлийг Япон хэл дээр бичсэн байна.
- Илтгэл нь оршил, үндсэн хэсэг, дүгнэлтээс бүрдсэн байх
- Илтгэлийг 5 минутад багтаан илтгэхээр тооцож текстээ бэлдэнэ.
- Үсгийн фронт MS明朝, үсгийн хэмжээ 11 байна.
- Илтгэлийн файлаа PDF форматаар холбооны info@ami.or.jp мэйл хаяг руу илгээнэ. Файлыг дараах байдлаар нэрлэж илгээнэ:
Овгийн эхний үсэг_Өөрийн нэр_Илтгэлийн сэдэв
Жишээ нь: A_Bat_Minii Hairtai Mongol oron

Хоёрдугаар шатанд:

- Илтгэлийг Япон хэл дээр илтгэнэ.
- Илтгэгч нь өөрийн биеэр ирж оролцоно.
(2-р шатанд шалгарсан боловч Токиогоос хол бүс нутагт амьдардаг эсвэл ирж оролцож чадахааргүй хүндэтгэх шалтгаантай тохиолдолд илтгэл тавьж буй видео бичлэгээ урьдчилан илгээж оролцох боломжтой)
- Нэгдүгээр шатанд ирүүлсэн илтгэлийн сэдэв агуулга өөрчлөгдөөгүй байх.
- Илтгэл тавих хугацаа 5 минут, асуулт хариулт 3 минут байна.
- Илтгэгч нь хувцаслалт, гадаад төрхөндөө анхаарсан байна.
- Хувь хүнийг нотлох бичиг баримтаа авчирсан байна.

AMJ-Япон дахь Монгол Иргэдийн Нэгдсэн Холбоо
Боловсрол, Соёл Урлаг, Спортын албаны
зохион байгуулах ажлын хэсэг